

КАНТЫН “ЦЭВЭР ОЮУН УХААНЫГ ШҮҮН ШИНЖЛЭХҮЙ”-Н СЭТГҮҮЛ ЗҮЙН АСУУДАЛ

Б.Болд-Эрдэнэ*

*МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн профессор,
сэтгүүл зүйн доктор (Ph.D)

Түлхүүр үгс: Иммануэл Кант, сэтгүүл зүй, танин мэдэхүй, мэдээлэл, үр нөлөө, цэвэр оюун ухаан, шүүн шинжлэхүй

Сэтгүүл зүй өргөн утгаараа нийгмийн мэдээлэл, нийгэмшүүллийн (зугаа цэнгэлийн) харилцаа юм. Тиймээс хүний оюун ухаанд нөлөөлдөг үү, тийм бол ямар замаар, үгүй гэвэл яагаад хэмээх асуулт бодитоор оршсоор байна. Оюун ухаан нь нэг бодлын төгс төгөлдөр, эрхэм дээд, нөгөө бодлын тодорхойгүй, эргэлзээтэй үнэлэлт дүгнэлтийн эрс тэс мэтгэлцээний сэдэв, асуудал мөн. Тэр дундаа цаг үеийн явдал, баримт, үзэгдлийг олон нийтэд түгээдэг, агуулга нь тохиолдлын, өөр хоорондоо шууд холбоогүй хэсэг бусаг чанартай, хэлбэр нь хамгийн сонирхолтой, онцгой дүр, дүрслэл, тэмдэгтийг сонгон үзүүлж, илэрхийлдэг гэдэг утгаараа танин мэдэхүй, оюун ухааны түвшинд “үл хүрэх мэдлэг” гэж хэлж болно. Гэхдээ цаг үеийн мэдээ, реалити шоу, олон ангит кино, олимпын тоглолтын шууд дамжуулал хүний оюун ухаанд хүрч, ямар нэгэн нөлөө үзүүлдэгтэй маргах аргагүй. Хүний үзэж өнгөрүүлсэн амьдралын туршлага, түүнээс үүдэх төсөөлөл, мэдрэхүй гэдэг ч

зөвхөн бодит ахуй, нөхцөл, орчноос төдийгүй үзэж, сонсож, уншсан мэдээллийн орон зайд оршин, төлөвшиж байгаад ч эргэлзэх ёсгүй. Хэрэв туршлагыг оюун дүгнэлтийг эх сурвалж хэмээвээс түүнээ мэдээлэл, тэмдэгт, бэлгэдлийн орон зай (сэтгүүл зүй) багтана. Мэдлэг, ухаанд нөлөөлөх ёстой нэгэн “хүч, хөдөлгүүр” гарцаагүй мөн.

Ийнхүү өгүүлэхийн учир “Цэвэр оюун ухааныг шүүн шинжлэхүй” их судрыг бүтээгч агуу их сэтгэгч Иммануэл Кантын үзэл онол, гүн ухаантай танилцах боломжийг их гүүш Ч.Даваадаш эрхэм хүн нээсэнд оршино.

Дээр өгүүлсэн сэтгүүл зүй ба хүний оюун ухааны холбогдол хамаарлын асуултын хариуг их сэтгэгчийн “...Тийм учраас л бид өөртөө буй юмсыг бус харин зөвхөн мэдрэмжийг тольдохуй (хар ухаан. зох) объектууд болох өөрөөр хэлбэл үзэгдлүүд болох зүйлсийг л танин мэдэж чадна (Кант.И, 2024) гэсэн дүгнэлтээс олж болохоор санагдлаа. Үнэхээр ч мэдээллийн жинхэнэ уг санааг (өөртөө буй юм) бус харин түүнийг хэрхэн ойлгож, үнэлж байгаа нь (үзэгдлүүд болон танин мэдэхүй) харилцааны (сэтгүүл зүйн) үр нөлөөг тодорхойлогч болно. Үр

нөлөө бол танин мэдэхүйн үйл явцын үр дүн хэмээвээс төсөөлөл (энэ нь үзэж өнгөрүүлсэн амьдралын туршлагаас хамаарч хүн бүрт өөр, өөр байна) итгэл үнэмшил (объектив биш ч субъектив чанартай байдаг) оюуны чадвар (туршлагаас үл хамаарч априор буюу хар ухаан) нь мэдээллийг ойлгох (хэрэглэхүй болгох буюу цаг үеэ дүгнэх, бусдыг үнэлэх, өөрийн эрх ашиг сонирхлоо хамгаалах эсхүл өөрчлөх зэрэг) үйл явцын (танин мэдэхүйн) хүчин зүйл болно. Мэдээлэл бол юмс юм хэмээн Кантынхаар дүйцүүлэн тодорхойлбол хүн аливаа мэдээллийг уг утгаар нь бус харин өөрт нь хэрхэн төсөөлөгдөж байна вэ, итгэл сэтгэлд нь нийцэж байна уу оюун бодол нь ухаарч чадаж байна уу гэдэг шалгуур боломжийнхоо түвшин, хүрээнд л ойлгодог.

Энэ тухай Кант "...Би зөвхөн өөрийн дотор байгаа тэрийг, өөрөөр хэлбэл гадаад юмсын тухай өөрийн төсөөллүүдийг л шууд ухамсарладаг... Гэхдээ би дотоод туршлагаараа дамжуулан цаг хугацаан дахь өөрийн оршин ахуйгаа (ингэхлээр бас цаг хугацаан дахь түүний тодорхойлогдсон чанарыг) ухамсарлаж байдаг... Тийнхүү цаг хугацаан дахь миний оршихуй нь энэ ухамсар надаас ангид оршигч ямар нэгэн юманд холбогдох холбогдлын адислал болох ухамсартай холбогддог. Тэгэхлээр уран сэтгэмж бус харин туршлага, дүрслэн бодох бус харин мэдрэхүй гадаад юмсыг миний дотоод мэдрэмжтэй салшгүй холбодог" (Кант.И, Цэвэр оюун ухааныг шүүн шинжлэхүй (орчуулагч Ч.Даваадаш), 2024) гэжээ. Үнэхээр мэдээллийн эрэлт, сонирхол, үр нөлөө нь хүний дотоод ертөнцийг гадаад орчинтойгоо тэнцвэржих, ямар нэгэн гадаад аюул зөрчлөөс зайлсхийх,

хамгаалах, хянах зэрэг амьд оршихуйн зайлшгүй мөн чанартай холбоотой. Тиймээс хүн зөв, ончтой гадаад орчноо төсөөлөн сэтгэхэд үзэж өнгөрүүлсэн амьдралынх нь туршлага болоод өдгөө цаг үеийнх нь мэдрэмж, шийдвэрлэгч хүчин зүйл болно.

Эндээс сэтгүүл зүйн үндсэн ойлголт болох мэдээллийг хүн хэрхэн ойлгодог, өгүүлж буй агуулгыг нь үйл явдал, юмс үзэгдлийг яаж төсөөлж ухамсарладаг, цаашилбал яаж нөлөөлдөг ямар шалгуур, үндэслэлээр бичлэгийн ур чадварыг үнэлэх вэ гэдгийг тодорхойлж болно. Тухайлбал сэтгүүл зүйн мэдээлэлд цаг хугацааны чанар буюу тухайн үеийн мэдрэмжийг бий болгох нь тэгэхдээ априор мэдлэгтэй холбох нь хүний оюун ухааны танин мэдэх үйл явцад нийцтэй болох нь ээ. Яг тийм загварт нийцсэн телевизийн мэдээллийн зүйл бол инфотейнмент сэтгүүл зүй бөгөөд цаг үеийн үйл явдлыг үзэгчдэд мэдрэмж, догдлол, бүхий үзүүлэх ингэхдээ "хүний түүх" "соёл иргэншлийн утга" "зөрчил өөрчлөлтийн шалтгаан" (өөрөөр хэлбэл априор утгатай болгохыг эрмэлзэх) зэрэг агуулгад оршоох ёстой хэмээн тодотгодог. Нөгөө талаар телевиз нь "төсөөлөл мэдрэмж" -ийн цогц тэмдэгтийн орчин (дүр, дүрслэл, үйл явдал, дуу, хөгжим зэрэг) төдийгүй харахуйн хэрэгсэл гэдэг утгаараа хүний дотоод ертөнцтэй салшгүй холбоотой тул дүрслэл бодохуйгаас (унших нь дүрслэн бодохуйтай холбоогүй) илүү туршлагын (мэдрэмж) ухамсарт нөлөөлөх нь гарцаагүй. Цаашилбал Кант "...тэгэхлээр бас "дотоод туршлага өөрөө миний дотор бус, надаас гадна оршдог ямар нэг тогтвортой юмнаас хамааралтай байдаг ба түүнд холбогдох

ямар нэг холбогдолд би өөрийгөө сэтгэх ёстой” гэжээ. (тал 50)

Орчин үеийн хүний мэдээлэл, харилцааны эрэлт, хэрэглээний хүрээнд интернэт, даяар сүлжээний орчин нь гадаад мэдрэхүйн бодит оршихуй болсон хэмээн үзвэл бидний цахим хэрэгслээс шууд хараат оюун ухааны хямрал, эрсдлийн үр дагавар ямар хүчтэй аюултайг хялбар ухаарч болно. Өөрөөр хэлбэл бидний сэтгэлгээ, хандлага, байр суурийг тодорхойлон эрхшээгч нь бүхнийг нэгтгэгч, хянагч, систем болох даяар сүлжээний орчин болсон гэсэн үг. Тиймээс “Би хэн бэ?, яах ёстой вэ? юуг дээдлэх вэ? зэрэг “Би” хэмээх ертөнцийн эзэн, хүч нь даяар сүлжээний орчин болж, улмаар сүлжээнд байх түүний дэг (алгоритм), шахалт нөлөөнд автагдах нь хүний оюуны оршихуйн гол зорилго болжээ. Ийнхүү бидний танин мэдрэхүйн мэдрэмжээр хүрэх зам (харах, төсөөлөх, хүртэх) нөгөө ойлголтоор сэтгэх зам (юмстай шууд холбоотой оюун дүгнэлт) аль алины “луужин” нь интернэт орчин болж, оюун ухааны хүнийсэл “болох бодит байдлаас илүү виртуал оршихуйд байх”-д (өөрөөр хэлбэл сүлжээнд гадуурхагдахгүй байх, түүний эрэмбэ, үнэлэлтээр бүхнийг үнэлж дүгнэх) оршиж, улмаар өөрийн дотоод мөн чанарыг бус харин сүлжээний хандалт, сонирхлын хүрээнд тогтоогдсон “дэг, хэв маягийг”-ыг эрхэмлэх болсон. Тийнхүү бурхан ч, хүн ч аль аль нь жанч халж, дижитал хэрэглээ бүхнийг хянагч, тодорхойлогч, “том ах” боллоо хэмээн Кантын үзэл шүүмжээр өнөөгийн хүний оюун ухааны хямралыг тунхаглаж болно.

Агуу их сэтгэгчийн цэвэр оюун ухааны шүүмж нь “...Бидний бүх танин мэдэхүй мэдлэг туршлагаас эхэлдэг нь эргэлзээгүй. Чухамдаа хэрэв бид-

ний мэдрэхүйг хөнддөг ба заримдаа өөрсдөө төсөөллүүдийг төрүүлдэг, заримдаа бидний оюун бодол объектуудыг харьцуулах, холбох юм уу хуваах, тийм янзаар мэдрэмжийн сэтгэгдлүүдийн бүдүүн тойм хэрэглэгдэхүүнийг туршлага гэж нэрлэгддэг биет зүйлсийн танин мэдэхүй болон боловсруулахад өдөөж өгдөг юмсаар биш юм бол чухамдаа өөр юугаар танин мэдэхүйн чадварыг үйл ажиллагаанд сэрээн турхирах вэ” (тал 53) хэмээн эхэлдэг. Энэхүү удиртгалын утга агуулгыг сэтгүүл зүйн хүрээнд, хүний мэдээлэл авах үйл, хэрэглээний орчинд буулгавал нийтлэл, нэвтрүүлэг, контент нь туршлага бөгөөд үзэгч, хэрэглэгч, уншигчдын үзэх, унших, сонсох мэдрэхүйд хүрч, тодорхой төсөөлөл, мэдрэмж өдөөдөг, сэтгэгдэл төрүүлдэг, түүнчлэн харьцуулал, хүнчлэл, амьдчиллаар төсөөлөгддөг объект нь дүр дүрслэл, дуу чимээ, үсэг, тэмдэгтийн орчин болж байна.

Гэхдээ мэдээллийн хэрэгслийн туршлага болох мэдээлэл нь нэг талаас бодит үйл явдал, үзэгдэл мөн боловч нөгөө талаас төлөөлүүлэн, сонгон авсан бодит бус объект мөн. Өөрөөр хэлбэл мэдээллийн орон зай (туршлагаар бүтээгдсэн мэдлэг) нь априор мэдлэгийн апостериор эх сурвалж (туршлагаас гаргаж авсан мэдлэг) байх зарчимд нийцэж байж сая зорилгодоо хүрдэг учраас объект нь хоёрдмол буюу бодит байдлын утга билэгдэлт төлөөлүүлэл байх учир шалтгаантай ажгуу. Үнэхээр ч олон нийтийн анхаарал, эрэлт сонирхлыг татсан, нөлөө бүхий мэдээлэл нь (нийтлэл нэвтрүүлэг, контент зэрэг) зөвхөн юм үзэгдлийн бус (дан туршлагад үйлчилсэн) цэвэр мэдлэг болох (априор) танин мэдэхүйн бүтээл байх ёстой. Мэдээллийн агуулга

илэрхийлэл нь үзэж, сонсож, уншиж буй хүний хүртэхүйн мэдрэмж таашаалаас болон түүний чадвар үзэж өнгөрүүлсэн амьдралын туршлагын төвшин, хүрээгээр төсөөлөгдөнө. Тэгэхдээ цаг хугацаа, орон зайн тодорхой шалтгааны үрээр (тогтвортой байнга эсвэл нийгэм, байгалийн өөрчлөлтөөс шалтгаалан) мэдрэмж илэрхийллээс өөр мэдлэг, түгээмэл зүй тогтлыг эрэлхийлдэг. Энэхүү эрэлт сонирхолд ч аналитик (задлан шинжилгээний) сэтгүүл зүйн апостериор зорилго оршдог. Гэхдээ хүний априор мэдлэгт сэтгүүл зүй хүрэх боломжгүй тул зөвхөн тэмүүлэх ёстой.

Учир нь "...зөвхөн аль нэг туршлагаас хараат бус, харин аливаа туршлагаас гарцаагүй хараат бус мэдлэгүүдийг априор гэж нэрлэх болно. Тэдгээр эмпирик мэдлэгүүд буюу зөвхөн апостериор боломжтой өөрөөр хэлбэл туршлагаар дамжин мэдлэгийн эсрэг байдаг. Мөн априор мэдлэгүүдээс эмпирик юу ч өөрт нь огт холилдоогүй тийм мэдлэгүүдийг цэвэр гэж нэрлэдэг. Үүнд жишээлбэл аливаа өөрчлөлт өөрийн шалтгаантай байдаг гэсэн үндэслэл бол априор үндэслэл гэхдээ цэвэр бус үндэслэл мөн. (тал 55) ажээ. Тэхлээр сэтгүүл зүй ер нийгэм, хүний бүхий л мэдээлэл, утга тэмдэгтийн орчин нь цаг үе үйл явдал, үзэгдлийн хүрээнд дүгнэлт тайлбараар тодорхойлогддог учир хамгийн дээд төвшиндөө апостериор байхаас цааш хэтрэхгүй, хэтрэх гээд ч боломжгүй юм. Гэхдээ априор мэдлэг гэж юу вэ, сэтгүүл зүйн мэдээлэлд тийм агуулга яагаад үгүй вэ, цаг үеийн тухай нийтлэл, нэвтрүүлгийн үнэ цэн юу вэ гэдэг асуулт хэнд ч төрөх нь гарцаагүй. Энэ тухай их сэтгэгч маань "нэгдүгээрт хэрэв түүний (объект) бидэнд зайлшгүй хамт сэтгэгддэг үндэслэл байх юм

бол энэ нь априор бодомж юм... хоёрдугаарт туршлага (үзэж, сонсож, унших зэрэг) хэзээ ч бодомжинд жинхэнэ буюу нарийн чанд түгээмэл чанарыг олгодоггүй... зөвхөн нөхцөлдмөл харьцангуй түгээмэл чанарыг (индукциэр дамжуулан) олгодог" хэмээн хариулжээ. Түүнийхээр зайлшгүй бөгөөд чинад түгээмэл чанар нь априор мэдлэг болой. Мэдээж сэтгүүл зүйн мэдээлэл нь зорилго, үүргээрээ зайлшгүйг бус тохиолдлыг (тухайн цаг үеийн чухал, мэдээлэх ёстой, сонирхолтой үйл явдал, үзэгдлийг тухайлдаг) чинад түгээмэл бус онцгой, санамсаргүйг өгүүлэхэд оршдог. Нөгөө талаар хүний танин мэдэхүйн ямар ч хэлбэр төвшин (телевиз үзэх, сонин унших, олон нийтийн сүлжээг ашиглах зэрэг) априор мэдлэгтэй холбоотой бөгөөд үүнгүйгээр туршлага (мэдээлэл хүртэхүй) хэзээ ч бодит мэдлэгийг нотлохгүй гэж Кант тайлбарлажээ. Хүний танин мэдэхүйн ертөнцийн мөн чанараар ч мэдээлэлд мэдлэг, мэдлэгт ухаан, ухаанд мэдээлэл орших нь зүй ёсны хэрэг. Кант априор бөгөөд нийлэг бодомжийн жишээг математик, байгалийн шинжлэл, метафизик дээр тодотгоод түүнийгээ "зайлшгүй түгээмэл чанар бүхий мэдлэг, үндэслэл"-д оршиж байна гэсэн. Хэдийгээр нийгмийн ухамсар, мэдээллийн хүрээнд априор мэдлэгийн тухай ярих боломжгүй хэмээн Кант онцолсон ч миний бие мэдээллийн априор чанарыг илэрхийлэгчээр харилцааг өргөмжилж байна. Ийнхүү тодорхойлохын учир нь Кантын "Юмстай гэхээсээ илүүтэй бидний юмсыг танин мэдэхүйн төрлүүдтэй ажилладаг аливаа танин мэдэхүйг би трансценденталь (янагуух) гэж нэрлэдэг. Учир нь энэ танин мэдэхүйн априор боломжтой байх

ёстой” гэж тайлбарласантай дүйцүүлэн үзэж байгаад оршино. (тал 72)

Үнэхээр харилцаа нь мэдээллийн агуулга, хэлбэр, утга санаа гэхээсээ илүү хүртэх, төсөөлөх, мэдрэх, сэрэх, санах, ухаарах зэрэг үйл явцаар үр нөлөө, зорилго нь оршдог танин мэдэхүйн ертөнц билээ. Энэхүү танин мэдэхүйн систем нь априор мэдлэгийг бүрэн хэмжээгээр агуулдаг янагуух философийг төрүүлэгч төдийгүй шүүн шинжлэхүйн цорын ганц үйл явц мөн. Нөгөөтэйгүүр хүн төрөлхтний оюун бодлын хөгжил, тэлэлт нь гагцхүү харилцааны эрч нөлөө “хөдөлгөөн”-өөр сая бодит зүйл болсон гэдэгтэй маргах аргагүй. Үүний жишээнд философийн адил шашин, ёс суртахуун, эрх зүй, гоо зүй гээд харилцааны бүх хэлбэр, төрөлд “цэвэр оюун ухааны өөрийн эдгээр зайлшгүй асуудал бол “Бурхан, эрх чөлөө, мөнх нас” (тал 59) танин мэдэхүйн, үйл зориглолыг багтааж болно. Энд би хүн төрөлхтний харилцааг бүхэлд нь нэгтгэн багтааж буйн хамт энэ хүрээ, төвшиндөө цаг хугацаа, орон зайтай энэ тэнцүү априор эх сурвалж хэмээн дүгнэж байна. Учир нь юмсыг мэдрэхгүйгээр хүртэж, оюун бодлоор сэтгэхүйн зайлшгүй чанар нь харилцаа юм. Хэрэв хүний оюун ухаан нь (тархи) харилцаа үгүйгээр (нийгэм, үнэлэхүй,

дэг журам, хэм хэмжээ) үнэ цэнэгүй хөгжил дэвшил шаардлагагүй (тархи нь шүднээс өөрцгүй эрхтэн) болно. Тэгэхлээр харилцаа нь априор мэдлэгийг илэрхийлэгч шалтгаан, зорилго бөгөөд цаг хугацаа, орон зайг нэгтгэгч хүч болж байна. Тийнхүү оюун ухааны зайлшгүй чанар нь цаг хугацаа, орон зайг, мэдрэх, танин мэдэх, эрхшээхэд оршин буй учраас оюун ухаан бол цаг хугацаа, орон зайн “тэжээлтэн” болж таарлаа. Ийнхүү нуршихын учир нь Кант “орон зай, цаг хугацаа нь туршлагаас үл хамаарах, мэдрэхүйн априор хэлбэрүүд” хэмээн үзсэнд оршиж байна. Гэхдээ энд оюун ухааны априор мэдлэгийг танин мэдэх зайлшгүй, априор хэлбэрүүдийн нэгтгэл нийлмэл (чинад түгээмэл) болгон сэрэх шалтгааныг орхигдуулсан (хоосон үлдсэн) нь тодорхой бөгөөд энэхүү орон

зайг эзэгнэгч нь харилцаа хэмээн бат ноттой итгэж байна. Харилцаа нь цаг хугацаа, орон зайн мэдрэмжийг эрхшээгч үйл явц төдийгүй априор мэдлэгээр хөтлөгдөн үр нөлөө, цар хүрээ, үнэлэлт ойлголт нь өөрчлөгдөж байдаг танин мэдэхүйн үйл явц мөн. Нөгөө талаар байгаль, ертөнцөөс гадна билэгдэл, итгэл үнэмшил, соёлын тэмдэгтийн зэрэг “оюун ухааны ахуй”-г бүтээдэг харилцаа нь хүний танин мэдэхүйн трансцендентал

«

Үнэхээр харилцаа нь мэдээллийн агуулга, хэлбэр, утга санаа гэхээсээ илүү хүртэх, төсөөлөх, мэдрэх, сэрэх, санах, ухаарах зэрэг үйл явцаар үр нөлөө, зорилго нь оршдог танин мэдэхүйн ертөнц билээ. Энэхүү танин мэдэхүйн систем нь априор мэдлэгийг бүрэн хэмжээгээр агуулдаг янагуух философийг төрүүлэгч төдийгүй шүүн шинжлэхүйн цорын ганц үйл явц мөн. Нөгөөтэйгүүр хүн төрөлхтний оюун бодлын хөгжил, тэлэлт нь гагцхүү харилцааны эрч нөлөө “хөдөлгөөн”-өөр сая бодит зүйл болсон гэдэгтэй маргах аргагүй

»

(янагуух) орчин, эх сурвалж билээ. Товчоор хэлбэл байгаль, ахуй шиг харилцаа нь нэгэн адил түвшинд хүний танин мэдэхүйг бүтээдэг гэсэн үг. Байгалийг таньж мэдэх нь шавхагдашгүй, харилцаанд эрхшээгдэх нь төгсгөлгүй гэдэг утгаараа ч хүний оюун ухааны ертөнцийн мөнхийн эх сурвалж болно.

Кант "...хүний танин мэдэхүйн үндсэн хоёр багана тухайлбал мэдрэхүй ба оюун бодол оршин байдгийг...юмсыг мэдрэхүйн чанараар дамжиж хүртдэг харин тэдгээрийг оюун бодлоор дамжин сэтгэдэг" (тал 76) хэмээн тодорхойлсон ч харилцааны мөн чанар болох хүний (оюун ухааны) дотоод (мэдрэмж, төсөөлөл, сэтгэгдэл) гадаад (байгаль, нийгэм, үйл явдал) ертөнцийн тэнцвэржилтийн оршихуйн зарчмыг тунхагласан хэрэг байжээ.

Мэдээллийн орон зайн танин мэдэхүйд хүртэгддэг нөхцлүүд (баримт, үйл явдал, үзэгдэл) сэтгэгддэг нөхцлүүдийг (үзэл санаа, байр суурь, санаа бодол) бүрдүүлдэг нь ч маргашгүй юм. Харилцааны (мэдээллийн) орон зай ч шашин улс төр, сэтгүүл зүй, реклам, PR зэрэг дэд бүсийг нэгтгэдэг, өөр хоорондоо уялдаа холбоотой нэгдмэл тогтолцоо мөн. Мэдээж өдгөө

Кантын томъёолж байснаар харилцааны априор танин мэдэхүйн бүрэн дүүрэн, нухацтай задлан шинжилгээ, мэдлэгийн жагсаалтыг гаргах нь маргаантай, үл гүйцэлдэх зорилго болоод байна. Гэхдээ зөвхөн харилцаанд л хүний оюун ухааны тольдохуй (хар ухаан) цэвэр априор мэдлэг нээгдэж, өргөжин тэлэхээс өөр зам, арга үгүй гэдэгт эргэлзэх хэрэггүй. Энэ утгаараа ч сэтгүүл зүй нь (мэдээллийн харилцаа гэдэг утгаараа) танин мэдэхүйн янагуух эх сурвалжтай холбоотой төдийгүй тийм байж үүрэг зорилгодоо үйлчилнэ.

Ашигласан бүтээл

1. Кант.И (2024) Цэвэр оюун ухааныг шүүн шинжлэхүй (орчуулагч Ч. Даваадаш) Улаанбаатар.

Summary

This paper explains the key concepts of cognition, effect, pure reason, judgment, as explained in the work of the great thinker Immanuel Kant "The Critique of Pure Reason", translated by Doctor of Philosophy, Professor Ch. Davaadash, on the concepts of journalism information, communication, and effect.

Keywords: Immanuel Kant, journalism, cognition, information, effectiveness, pure reason, jurisprudence.